



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

145 /145/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.09.29

ЦАХИМ ШУУДАНД

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛЛАЖ БАЙНА



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай өнөөдөр БХЯ-ны харьяа байгууллагуудад ажиллана. Яг энэ цаг мөчид

“Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт ажиллаж байгаа бөгөөд



дараа нь “Бөртэ” цэргийн оёдлын үйлдвэрт ажиллах ажээ. Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай болон бусад

албаны хүмүүсийн БХЯ-ны харьяа байгууллагуудад ажилласан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг маргаашийн дугаараар хүргэх болно.

Түүхэнд энэ өдөр

2009 он:

Афганитанд АНУ-ын тэргүүлсэн Эвслийн хүчний “Тогтвортой эрх чөлөө” цэргийн ажиллагаанд цэргийн хамгаалалтын ротын илгээв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
6	-7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
29	15

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,851.00
EUR	3,346.0	3,354.0
CNY	441.2	442.5
RUB	38.70	39.90
JPY	25.44	25.88
KRW	2.37	2.45

ЗУРХАЙ

2021.09.29 ЛХАГВА ГАРГАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 23/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САР, ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Идээ ундаа элбэг олдono Наран ургах, шингих: 06.47-18.37

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Хий

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

АРМИЙН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ БОКСЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН БАГ ТАМИРЧИД ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



ОХУ-ын Москва хотод зохиогдсон Дэлхийн аварга шалгаруулах Армийн 58 дахь удаагийн боксын тэмцээнд 36 орны 250 гаруй тамирчид өрсөлдлөө. Тус тэмцээнд Монгол Улсын Батлан хамгаалах яамны харьяа, Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооноос 7 тамирчин, 1 шүүгч, 1 дасгалжуулагч эх орноо төлөөлөн оролцсон юм. МУГД хошууч А.Гантулга дасгалжуулагчтай баг 2 мөнгөн медаль, 1 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцож багийн дүнгээр 36 орноос 6 дугаар байрт бичигдлээ. Тодруулбал, 56 кг-ийн жинд үндэсний шигшээ баг, “Алдар” спорт хороо, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, “МАК” компанийн тамирчин ОУХМ, дэслэгч Х.Энх-Амар, 52 кг-ийн жинд үндэсний шигшээ баг, “Алдар” спорт хороо, “МАК” компанийн тамирчин ОУХМ, ахлагч Х.Энхмандах хүрэл, мөн 57 кг, эмэгтэйчүүдийн төрөлд “Алдар” спорт хороо, “Жунсон” компанийн тамирчин ОУХМ,

Т.Болортуул мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ. Тэгвэл эдгээр баг тамирчдыг “Алдар” спорт хорооны дарга, МУГТ, хурандаа Г.Өсөхбаяр хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Тэрээр “Бид өмнөө тавьсан зорилго зорилтуудаа биелүүллээ гэж бодож байна. Тухайн улсын спортын шилдэг тамирчид нь Зэвсэгт хүчний баг бүрэлдэхүүнд байдаг. Энэ ч утгаараа Армийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүд асар их ур чадвар шаарддагаас гадна ширүүхэн өрсөлдөөн үзүүлдэг. Удахгүй болох боксын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн манай баг тамирчид оролцох ёстой. Нэг ёсондоо Армийн Дэлхийн аваргын тэмцээн өөрсдийгөө сорьсон, сорил гэж хэлж болохоор тэмцээн байлаа. Дахин баяр хүргэе, баг тамирчдадаа спортын өндөр амжилт хүсье” гэв. Х.Энх-Амар, Х.Энхмандах нар төрсөн ах дүүс бол, Т.Болортуул Х.Энх-Амарын эхнэр юм.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 293.371 +2153	ЭДГЭРСЭН 311.595 +7262	НАС БАРСАН 1162 +17
-----------------------------------	---------------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5242 +90	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 180	ЭДГЭРСЭН 4962
-----------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 233,520,528
Эдгэрсэн Нийт: 210,326,866
Нас барсан Нийт: 4,769,271

цахим шууданд

“НУТГИЙН ГЕНЕРАЛ” ХҮНДЭТГЭЛИЙН ТАЛБАЙГ ШИНЭЧЛЭН ЗАСВАРЛАВ



Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Завхан аймгаас эх орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг батлан хамгаалах, хилийн халдашгүй дархан байдал, энх цагийн бүтэн байгуулалт, ард түмнийхээ амгалан тайван байдлын төлөө мэдлэг чадвар, авьяас билиг, ажил амьдралын арвин их туршлагаа эгнэгт зориулан зүтгэж ирсэн хорин таван генерал цолтон төрсөн билээ.

Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан тус аймгаас төрөн гарсан Монгол Улсын генералуудынхаа алдар гавьяаг мөнхжүүлж, дайчин уламжлалыг ирээдүй хойч үедээ өвлүүлэх, сурталчлан таниулах, монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэх, хотын өнгө үзэмжийг сайжруулах, “Монгол цэргийн өдөр”, “Генералуудын өдөр”, “Генералуудын өдөр” зэрэг түүхэн ой, тэмдэглэлт баяр, хугацаат цэргийн албанд татагдсан дайчдыг үдэн гаргах, угтан авах ёслол хүндэтгэлийн арга

хэмжээг зохион байгуулах, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг болох, олон нийт, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчныг бий болгох зорилгоор “Нутгийн генералууд” хүндэтгэлийн талбайг шинэчлэн засварлав.

“Нутгийн генералууд” хүндэтгэлийн талбайн нээлтийн үйл ажиллагаанд Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Улам-Оргих, Завхан аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, бэлтгэл дэд хурандаа Н.Тэрбиш, бэлтгэл дэд хурандаа Д.Дэчинсамбуу, Аймгийн Засаг даргын орлогч Ш.Мянганбаяр, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Үнэнбаяр, Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн захирагч, хурандаа

Г.Чулуунзагд, Хилийн 0277 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Уламжаргал, Аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ө.Болд, Аймгийн Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа Н.Отгонжаргал, Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа Б.Батжаргал, Тагнуулын Ерөнхий газрын Завхан аймаг дахь хэлтсийн дарга, хурандаа А.Арсланбаатар, Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн дарга, 24 сумын Засаг дарга нар оролцлоо.

“Нутгийн генералууд” хүндэтгэлийн талбайг аймгийн албан байгууллага, ард иргэдийн хандив, Зэвсэгт хүчний 339, 325 дугаар ангиуд, аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, ШШГГ-ын алба хаагчид дотоод нөөц боломжоор Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн ахмад Ч.Эрхэмбаатар ахлагчтай барилгын бүлэг хийж гүйцэтгэлээ.

Хошууч Г.БАВУУДОРЖ

“ТОЙМ МЭДЭЭ”, “СУДАЛГААНЫ ТОЙМ” ТАНЫ ГАРТ



Олон улсын болон нутгийн аюулгүй байдлын орчны төлөв байдалд дүгнэлт хийж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба БХЯ, ЗХЖШ-ын удирдлагыг цаг үеийн мэдээллээр хангах долоо тутмын “Тойм мэдээ”, улирал тутмын “Судалгааны

тойм”-ыг гаргаж байна. Тэрчлэн эрдэмтэн судлаачдын Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, цэргийн байгуулалтын асуудлыг хөндсөн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлүүдийг эмхэтгэн “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал”

ISSN” дугаартай сэтгүүлийг жилд хоёр удаа хэвлэн судалгааны эргэлтэд оруулж байгаа юм.

Олон улсын аюулгүй байдал, цэрэг, улс төрийн тойм (2021.09.18-2021.09.24) мэдээнээс хүргэж байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Ойрын өдрүүдэд цаг агаарын байдал муудаж, цас бороо ихээр орж замын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотой зам тээврийн осол зөрчил ихээр бүртгэгдэх болсон тул Зэвсэгт хүчний анги байгууллагын тээврийн хэрэгслийн жолооч нар хот суурингаас хөдөө орон нутгийг зорихдоо тээврийн хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг шалгаж, өвлийн дугуйгаа тавьж, замын хөдөлгөөний дүрмээ чанд мөрдөж, батлагдаагүй зам маршрутаар явахгүй байхыг Зэвсэгт хүчний тээврийн хяналтын албанаас сэрэмжлүүлж байна.

Зэвсэгт хүчний тээврийн хяналтын албаны урьдчилан сэргийлэх олон нийттэй харилцах мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Д.ГАНХУЯГ

ЗАСАГ ДАРГА НАРЫН ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТ БОЛОВ



Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайд болон Нийслэлийн Засаг даргын 2021 онд хамтран ажиллах гэрээний дагуу Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн материаллаг баазыг



түшиглэн зохион байгуулж, тус дүүргийн 21 хорооны Засаг дарга нар хамрагдлаа. Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн товч танилцуулга, түүхэн замнал, “Дайчин алдар”-ын танхимыг тус ангийн штабын дарга, дэд хурандаа О.Энх-Амар хорооны Засаг дарга нарт танилцуулсан. Энэхүү сургалтын төгсгөлд дүүргийн Цэргийн штабын дарга, хурандаа Г.Жаргалсайхан хорооны Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч, сургалтад оролцсон “Батламж”-ийг гардуулж, амжилт хүслээ.

КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 089 дүгээр анги “Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газар, түүний харьяа ангиудын удирдлага, штаб, үүрэг гүйцэтгэх томилгоот бүлгүүд, төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн удирдах

газрын Материал, техникийн хэлтсийн бүрэлдэхүүнтэй команд штабын болон тусгай тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулж байна. Энэхүү команд штабын болон тусгай тактикийн хээрийн сургууль нь 2021 оны 9 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд явагдах бөгөөд Зэвсэгт хүчний Ар талын байгууллагын 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын нэг


болж байгаагаараа онцлог юм. Сургуульд ЗХЖШ-ын Материал, техникийн газар, төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн удирдах газрын Материал, техникийн хэлтэс, Зэвсэгт хүчний 011, 015, 089, 310, 314, 334 дүгээр ангиудын удирдлага, штабын бүрэлдэхүүн оролцож байна. Ахмад Б.НОРОВ-ЭРДЭНЭ

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ НЭМЭЛТ ЭЛСЭЛТ АВНА

Улс орны батлан хамгаалах эрэлт, хэрэгцээ шаардлагын дагуу ҮБХИС нь нэмэлт элсэлт авч эхэллээ. Тодруулбал, эдийн засаг, менежмент, авто инженер, цэргийн хими хамгаалалт, зенитийн артиллери, зенитийн пуужин, радиотехникийн команд, цэргийн зэвсэглэл, артиллери, цэргийн инженер, хуягт танкийн команд гэсэн мэргэжлээр 9 дүгээр сарын 27-аас 30-ны өдрүүдэд 10.00–16.00 цагийн хооронд элсэгчдийг бүртгэж байна. Бүртгүүлэгчид нь Цэргийн мэргэжлийн бакалаврын

хөтөлбөрт элсэгчид 165 см-ээс дээш өндөртэй, 60 кг-аас багагүй жинтэй, биед шивээсгүй, биеийн ил хэсэгт сорвигүй, элдэв гаж зуршилгүй, сэтгэц эрүүл байх шаардлагуудыг хангасан байна. Эх орноо батлан хамгаалах их үйлсэд хүчин зүтгэхийг хүсэгч хэн бүхнийг ҮБХИС урьж байна. Холбогдох утасны дугаар: 453164, 89090682, 99077929 Бүрдүүлэх бичиг, баримт: - Иргэний үнэмлэхийн хуулбар /2 хувь/;

- Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж /2019, 2020, 2021/; - Б о л о в с р о л эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг; - Сурагчийн хувийн хэрэг; - 3x4 хэмжээний цээж зураг /4 хувь/; - Төгссөн сургуулийн тодорхойлолт; - Өөрийн суралцах бэлтгэл, авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн эсээ бичлэг; - Гурван үеийн намтар.



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ. * Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхтэй ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ. * Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисуудын ордон Индекс: 10018 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

ЦАХИМ ХАЯГ Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС "Соёмбо" сонин "Дуулга" студи